



**“ГУТАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2024 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 46, 47 дугаар зүйлийн, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь хэсэг, 80 дугаар зүйлийн 80.6 дахь хэсэг, “Гутал” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.31.8 дахь хэсэг, 2024 оны 02 дугаар сарын 07-ний өдрийн “Гутал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Гутал” ХК нь 2023 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашиг, мөн үеийн санхүүгийн нөхцөл байдал, эрсдэлийн зохистой харьцаа зэргийг үндэслэн нэгж хувьцаанд 1400 /нэг мянга дөрвөн зуун/ төгрөгтэй тэнцэх ногдол ашиг хуваарилсугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдрөөр буюу 2024 оны 03 дугаар сарын 15-ний өдрөөр тогтоосугай.
3. 2023 оны сүүлийн хагас жилийн ногдол ашгийг 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн холбогдох хууль, журмын дагуу олгохыг гүйцэтгэх удирдлагад үүрэг болгосугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**



Б.БАТБИЛЭГ